



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/629

Мөрөн сум

Төсөл баталгаажуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 зүйлийн 18¹.1.2, Засгийн газрын 2020 оны А/113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.5.7 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Төсөл сонгон шалгаруулах дэд хорооны шийдвэрийн дагуу жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх төслийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар баталсан төслийн жагсаалтыг Жижиг, дунд үйлдвэрийн газарт хүргүүлэхийг төсөл сонгон шалгаруулах дэд хорооны дарга (Я.Эрхэмбаяр)-д даалгасугай.


3. Жижиг, дунд үйлдвэрийн газраас олгох зээлийн хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээ байгуулах, ажлын явцын талаар тайлагнаж ажиллахыг Төсөл сонгон шалгаруулах дэд хорооны дарга (Я.Эрхэмбаяр)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ө.Улам-Өсөх)-д даалгасугай.

ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР





Аймгийн Засаг Даргын 2023 оны 14 дугаар сарын 05-ны
өдрийн А/629 дугаар захирамжийн хавсралт

жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт
БАГТСАН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ

№	Бүртгэлийн код	Төсөл ирүүлсэн аж ахуйн нэгжийн нэр	Регистри йн дугаар	Захирлын овог нэр	Төслийн чиглэл	Хаяг	Батлагдсан дүн /сая.төг/	Нийт оноо	Эрэмбэ
1.	Sme-23-01538	"Өөдлөх галт" хоршоо	4126955	Магсаржав Энхбаяр	Мах нядалгааны цэг байгуулах	Хөвсгөл аймаг Галт сум 5-р баг 407 тоот	166.0	307	I

-----oOo-----